

БАТЛАВ:

ТҮМЭНЦОГТ СУМЫН УС ДУЛААН ААТҮГ-ЫН  
ДАРГА *[Signature]* Б.ЛЭГЗИЙМАА  
2022 оны 02 сарын 23 өдөр

Ус-Дулаан ААТҮГ-ын Техникийн нөхцөл олгох комиссын 2022 оны 02 сарын 23-ний өдрийн хурлаар зөвшөөрөл олгов.

### Техникийн нөхцөл № 01/2022

- 1.Хэрэглэгчийн нэр: Түмэнцогт сумын Эрүүл мэндийн төвийн шинэ барилга
- 2.Барилгын мэдээлэл: 2давхар 17 ортой ЭМТ-ийн шинэ барилга
- 3.Хэрэглэгчийн байршил: Түмэнцогт сум 3-р баг
- 4.Дулааны хэрэглээ: Нийт:

А.Халаалт	60000 ккал/цаг
Б.Цэвэр усны хэрэглээ	2.21 м/куб / хоног
В.Бохир ус татан зайлуулах	2.21 м/куб/ хоног
Г. Агаар сэлгэлт -	40000ккал/цаг

5	Дулааны холболтын цэг	Дулаан дамжуулах 14 дүгээр худгаас өөрийн байгууллагын 15 дугаар худаг хүртэлх дулаан дамжуулах 40м халаалтын Ø76 шугмыг шинэчлэж дулаан авах. Хэрэглээний халуун усаар хангах техникийн боломжгүй ба хэрэглээний халуун усыг цахилгаан бойлер байдлаар шийдвэрлэх. Дулаан түгээх цехийн сүлжээний усны эргэлтийн насосыг CNP TD 100-48/2 маркийн 2 ширхэг, 22.квт-ын насосоор өргөтгөх
6	Цэвэр усны холболтын цэг	Цэвэр усны худгийг дулаан хангамжийн шугам сүлжээтэй нэг цэг авч. Нэг сувагт байршуулан пенополиуретан дулаалгын материалаар дулаалгыг хийж, зэврэлтээс хамгаалах түрхлэг хийх. Дулаан түгээх 14-15 дугаар худгийн хооронд 40м хүйтэн усны Ø 50 шугмыг шинэчилсэн тохиолдолд хүйтэн усны холболтыг хийх.
7	Бохир усны холболтын цэг.	Гадна ариутгах татуургын шугамыг барилгын урьд хэсгийн бохир усны трассын дагуух , одоо байгаа бохир усны худагт холболт хийх. БУХ..2/3 2/1-БУХ хүртэлх бохир усны худагт угаалга хийх.

### 8. Мөрдөж хэрэгжүүлэх хууль, дүрэм журам.

8.1 Эрчим хүчний тухай хууль

8.2 Засгийн газрын 2001 оны 12-р сарын 5-ны өдрийн 263-р тогтоолоор батлагдсан “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”



8.3 Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10-р сарын 11-ний өдрийн 290-р тогтоолоор батлагдсан “Дулаан дамжуулах, түгээх сүлжээний холболтын журам”

8.4. Эрчим хүчний тухай хуулийн 14-р зүйлийн 14.4-т заасны дагуу эрчим хүч дамжуулах шугам, дэд станц нь төрийн өмчлөлд байна.

8.5 Эрчим хүчний тухай хуулийн 30-р зүйлийн 30.1.13-т заасны дагуу эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 3-р сарын 31-ны 107 –р тогтоолоор нийтийн орон сууцны барилгуудын эрчим хүчний дэд станц шугам тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх нөхцөл хангасан тохиолдолд дулааны эрчим хүчээр хангана

### **9. Зураг төсөл, төсөв боловсруулахад тавигдах шаардлага:**

#### **9.1 Зураг төслийн үндсэн шаардлага**

9.1.1 “Эрчим хүчний тухай хууль” –ийн 33-р зүйл “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 1.3 дах заалтыг мөрдөж дулааны төв шугам, салаа болон салбар шугамаар хамгаалалтын зурвасын зайг хангаж барилгыг төлөвлөх. Шугамын хамгаалалтын зурвас тохижилт, зам талбай, зогсоол, бусад байгууламж төлөвлөхгүй байх.

Боловсруулсан: Ерөнхий инженер



Э.Отгонтөгс

Сүхбаатар аймаг. Түмэнцогт сум.

17 ОРТОЙ ЭМНЭЛЭГ

1. Халаалтын систем – 60 000 ккал/ц
2. Агаар сэлгэлт – 40 000 ккал/ц
3. Халуун ус – 47 000 ккал/ц
4. Цэвэр ус – 2,21м3/хон
5. Бохир ус – 2,21м3/хон
6. Галд – 2,5л/с

Golomturguu2003@gmail.com Ц.Баянмөнх Зургийн компани архитектороос  
2022 оны 02 сарын 24 нд хүлээн авлаа.

Хүлээлгэн өгсөн :



ЭМГ-ын удирдлага  
төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга  
О.Баярбаатар



БАТЛАВ. БЗӨБЦТС ТӨХК-ИЙН ХЭНТИЙ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ

САЛБАРЫН ДАРГА

С.БОЛД

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТҮР ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2022 оны 03-р сарын 01-ний өдөр

№ 10/22

Чингис хот

1. Техникийн нөхцөл  
хүссэн иргэн, хуулийн этгээд  
болон байгууллага:

Сүхбаатар аймаг, Түмэнцогт сумын Эрүүл Мэндийн  
Төв

2. Хэрэглэгчийн хаяг:

Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум, 3-р баг 88161418

3. Хэрэглэгчийн байршил,  
зэрэглэл:

Сүхбаатар аймаг, Түмэнцогт сум, I зэрэглэл

4. Ажил үйлчилгээний  
зориулалт:

Түмэнцогт сумын 17 хүний ортой эрүүл мэндийн  
төвийн барилга

5. Техникийн нөхцөл  
олгох үндэслэл:

Сүхбаатар аймаг, Түмэнцогт сумын ЭМТөвийн 2022  
оны 02-р сарын 23-ны өдрийн 08 тоот албан  
хүсэлтийн дагуу

6. Суурилагдсан чадал:

138 кВт

7. Холбогдох цэг:

7.1 10/0.4 кВ КТПН-158 дэд өртөөний 0.4 кВ  
Төсөв гаргалгааны тулгуур №8-д байрлах  
хэрэглэгчийн хоёр ширхэг цитийг 80\*100  
харьцаатай иж бүрэн цит болгон угсарч объект  
хүртэл 3\*95+1\*50 мм<sup>2</sup>-аас багагүй хөндлөн огтлолын  
талбайтай газарт булах зориулалт бүхий хос кабель  
шугам татаж төгсгөлд нь хэрэглэгч өөрийн ачаалалд  
тохирсон автомат гал хамгаалагч бүхий иж бүрэн  
цит угсарч суурилуулсан байна.

- 10/0.4 кВ КТПН-158 дэд өртөөний 0.4 кВ Төсөв  
гаргалгааны 3\*70+1\*50 мм<sup>2</sup> хөндлөн огтлолын  
талбайтай кабель шугамыг 3\*120+1\*70 мм<sup>2</sup>-аас  
багагүй хөндлөн огтлолын талбайтай газарт булах  
зориулалттай кабель шугамаар сольж холбосны  
дараа хэрэглэгчийг ЦЭХ-ээр хангана.

- Цахилгаан эрчим хүчний хэрэглэгчдийн  
найдваржилтийн зэрэглэл тогтоох журам, эрчим  
хүчний тухай хуулийн 30.2 дахь заалт, эрчим хүчээр  
хангах гэрээний 2.2.4 дэх заалтын дагуу өөрийн  
хэрэгцээний хүчин чадалд тохирсон нөөц эх үүсвэр  
бэлтгэж 0.4 кВ кабель шугамын төгсгөлд байрлуулан  
автомат төхөөрөмжөөр тоноглох.



## 8. Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 Монгол Улсын Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвөөс загварын туршилтад орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан 400/5 А гүйдлийн трансформатор бүхий 3 фазын 5 А-н олон үйлдэлт электрон тоолуураар КТПН-158 дэд өртөөний ерөнхий тоолуур, гүйдлийн трансформатораар сольж, 10/0.4 кВ КТПН-158 дэд өртөөний 0.4 кВ төсөв гаргалгааны тулгуур №8-д шинээр байрлуулсан хэрэглэгчийн щитэнд 250/5 А гүйдлийн трансформатор бүхий 5 А олон үйлдэлт электрон тоолуурыг таслах залгах автоматын хамт угсарч ЦЭХ-ний тооцоо хийх.

## 9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр баригдах объектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.

9.2 Шинээр угсрах кабель шугамын трассын зураг схемийг Хэнтий ЦТСС-ийн инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн щит тоноглолыг "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-д заагдсаны дагуу 4 Ом-оос ихгүй байхаар газардуулсан байна.

9.4 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.

9.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдэлийн түвшний  $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

9.6 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг Хэнтий ЦТСС-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.



9.8 Хэрэглэгч нь өөрийн тоног төхөөрөмжийн хүчин чадалд тохирсон хамгаалалтын төхөөрөмж /фазын хамгаалалт/ тавьж хамгаална.

10. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт БЗӨБЦТС ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтад хүлээн авах журам"-ийн дагуу холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар Шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бүс, барилга байгууламж барих, өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Энэхүү техникийн ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.


Техникийн нөхцөл олгосон:

ТҮАХМ, Ерөнхий инженер



Б.Одбаяр

ХҮА хариуцсан менежер



Ч.Ариунаа





БАТЛАВ

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ ХХК – ИЙН  
СҮХБААТАР АЙМГИЙН ГАЗРЫН ДАРГА /Д. БАТ-ЭРДЭНЭ/

Техникийн нөхцөл



20<sup>22</sup> оны 03 сарын 07 өдөр

Дугаар: 22/04

**Захиалагч байгууллага:**

**Гүйцэтгэгч байгууллага :**

**Харилцах утас:**

1. **Байршил:** Сүхбаатар аймаг Түмэнцогт сум
2. **Зориулалт:** Түмэнцогт суманд шинээр баригдах ЭМТ-ийн 17 ортой шинэ эмнэлэгийн барилгыг шилэн кабель татаж холбоожуулах
3. **Техникийн нөхцөлийн үндэслэл:** Харилцаа Холбооны Зохицуулах хорооноос олгогдсон сүлжээ байгуулах бүрэн эрхийн дагуу шилэн кабель болон физик кабель татах техникийн нөхцлийг зөвхөн "Мэдээлэл холбооны сүлжээ ХХК" олгоно. Техникийн нөхцөлийн дагуу холбооны шугам сүлжээг хийгээгүй тохиолдолд тухайн барилгыг улсын комисст хүлээн авахгүй болно.
4. **Техникийн нөхцөл:**
  - 4.1 МХС ХХК-ний ашиглагдаж байгаа холбооны байрны оролтын худгийн шилэн кабелийн муфтынээс баригдаж байгаа барилга хүртэл 250м шилэн кабель шинээр татах.
  - 4.2 Шинээр 3ш худаг, 250м сувагчлал 1 яндантай 1.0 метрийн гүнд газраар хийх.
  - 4.3 Төгсгөлийн худгаас барилга хооронд сувагчлал хийж шаардлагатай.
5. **Зураг төсөвт зайлшгүй тусгах шаардлагатай онцгой нөхцлүүд:**
  - 5.1 Шинээр хийгдэх кабель, шугамын угсралтын ажлын зураг төсвийг зохиохдоо Монгол улсын стандарт MNS 5276:2003, MNS 5279:2003, MNS 5280:2003, MNS 5277:2003 тоот ерөнхий шаардлагууд болон ДБХ-ийн сайдын 1995 оны 127-р тушаалаар батлагдсан зааврыг баримтлан гүйцэтгэх.
6. Тухайн шинээр хийсэн холбоожуулалтын трассын зураглалыг аймгийн газрын кадастрын зураглал болон мэдээллийн санд оруулах ба тэмдэглэл зураглалыг гаргаж өгөх.
7. **Угсралтын ажлын үед тавигдах нөхцөл:**

Угсралтын ажил эхлэхээс өмнө зураг төсөв техникийн нөхцлийн дагуу хийгдсэн эсэхийг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ний Сүхбаатар аймгийн газрын Ерөнхий инженер Б.Ананд (утас: 70510123, 99909084,) хянуулан баталгааг авсан байх.

Газар шорооны ажил гүйцэтгэхдээ харъяалагдах тухайн кабель шугамын инженерээр шалгуулан далд ажлын акт үйлдэж, хүлээн авах ажлын актанд хавсаргах.



**8. Шаардлагатай материал:**

- Шилэн кабелийн төгсгөлийн төхөөрөмж
- Шилэн кабель
- Бусад материал

8.1 Техникийн нөхцлийг 2022 оны 03-р сарын 07-ний өдөр олгов.

Угсралтын ажил дууссаны дараа хэмжилт, шалгалт хийлгэж тогтоосон журмын дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний Сүхбаатар аймгийн газарт техникийн актаар хүлээлгэн өгсний дараа сүлжээнд холбох зөвшөөрлийг авна.


**Энэхүү техникийн нөхцөл нь олгогдсон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.**

Техникийн нөхцөл хянасан: *Б. Ананд* Ерөнхий инженер /Б.Ананд/

Техникийн нөхцөл гаргасан: *Т. Ууганзол* К/Ш/инженер /Т.Ууганзол/



Хойд



Зүүн

Баруун

Урд

“Мэдээлэл Холбооны сүлжээ” ХХК-ийн Сүхбаатар аймгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 04 тоот техникийн нөхцөлийн хавсралт №1

## Сүхбаатар аймаг Түмэнцогт сумын нутаг дэвсгэрт баригдах 17 ортой эмнэлэгийн холбоожуулалтын трасс зураглал



Image © 2021 CNES / Airbus  
© 2021 Google

Go

МХС-ний худаг



Шинээр хийх худаг



Шинээр хийх сувагчлал

